



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/250

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа сунгах,
хаягийн өөрчлөлт бүртгэх, эрх сэргээх, хүчингүй
болгох, төсөл дэмжигдээгүй тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 16, 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.2 дугаар зүйлийн 11, 6.1 дүгээр зүйлийн 1.1, 8.1 дүгээр зүйлийн 13.17, 13.18, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2, 19.18, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын 2024 оны "Тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай" А/57 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, худалдах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 14 дүгээр хурлын шийдвэрийн дагуу Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох байгууллагын жагсаалтыг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, хаягийн өөрчлөлтийг бүртгэх, нэмэлт агуулах бүртгүүлэх байгууллагын жагсаалтыг хоёрдугаар, тусгай зөвшөөрлийн эрх сэргээх байгууллагын жагсаалтыг гуравдугаар, тусгай зөвшөөрлийн чиглэлийг хүчингүй болгох байгууллагын жагсаалтыг дөрөвдүгээр, төсөл болон ажлын байр дэмжигдээгүй байгууллагын жагсаалтыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагыг арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар (Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга Т.Мөнхтуул), Чанарын хяналтын газар (Ш.Энхтуяа)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (П.Мөнхжаргал)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




P. Altan

П.АЛТАНЦЭЦЭГ

1524 010250


Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2024
оны 12 дугаар сарын 09 -ны
өдрийн А/ дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт 240



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Нэг. Нийслэлд шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллагууд				
1.	Медигас ХХК РД: 5591937	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох-ханган нийлүүлэх	СБД, 1-р хороо, 14-р байр Элит оффис 304 тоот	2027.12.03
2.	Номт Нутрифарма ХХК РД: 7066441	Эм, эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн хэрэглэгдэхүүн) импортлох-ханган нийлүүлэх	ЧД, 3-р хороо, Жуулчдын гудамж, 38 тоот "Тайваны төв"- ийн 2 давхарт 205 тоот	2027.12.03
3.	Дэвжих ган харш ХХК РД: 6648398	Эм, эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн хэрэглэгдэхүүн) импортлох-ханган нийлүүлэх	СБД, 9-р хороо, 7-р хороолол, Их тойруу гудамж 54-р байр "Компьютер малл" 5 давхарт 5003 тоот	2027.12.03
4.	Спэйшил лидер трейд ХХК РД: 7076025	Эм, эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн хэрэглэгдэхүүн) импортлох-ханган нийлүүлэх	БЗД, 16-р хороо, 16-р хороолол, хд49/13 тоот 1-р давхар	2027.12.03
Хоёр. Орон нутагт шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллагууд				
5.	Хэнтий эм хангамж ХХК РД: 4186249	Эм, эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн хэрэглэгдэхүүн) импортлох-ханган нийлүүлэх	Хэнтэй аймаг, Хэрлэн сум 1-р баг Тэмүүжингийн гудамж	2027.12.03
6.	ЭХНБ дархан ХХК РД: 4286103	Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм импортлох-ханган нийлүүлэх	Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг, Баян-Идэр төвийн 1-р давхар	2027.12.03

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2024
оны 12 дугаар сарын 09 -ны
өдрийн А/ дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт 250




ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАХ, ХАЯГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ
БҮРТГЭХ, НЭМЭЛТ АГУУЛАХ БҮРТГЭХ БАЙГУУЛЛАГУУД

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Нэг. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах байгууллагууд				
1.	Мобио ХХК РД: 2724421	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох-ханган нийлүүлэх	ХУД, 15-р хороо, Нарны зам 10, Шинэ тэрэг плаза 1-р давхар	2029.10.03
2.	Медстар Эрдэнэ ХХК РД: 5281113	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох-ханган нийлүүлэх	СБД, 1-р хороо, UBH center оффисын барилга, 2 давхар, 206 тоот	2029.10.23
3.	Өлзий дэн ХХК РД: 2635321	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох-ханган нийлүүлэх	БГД, 1-р хороо, Хатанбаатар Магсаржав-36	2029.09.22
4.	Ига ХХК РД: 5635616	Эм, эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн хэрэглэгдэхүүн) импортлох-ханган нийлүүлэх	ХУД, 18-р хороо, Академийн гудамж Токио таун 50/4 102 тоот	2029.12.06
5.	Өргөөфарм импекс ХХК РД: 2774445	Эм, эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн хэрэглэгдэхүүн) импортлох-ханган нийлүүлэх	ЧД, 2-р хороо, Төмөрчний гудамж 2 тоот	2029.12.09
6.	Роторжен ХХК РД: 5386373	Эмнэлгийн хэрэгсэл импортлох-ханган нийлүүлэх	БЗД, 14-р хороолол, Намьянжүгийн гудамж 31/а байр, 3, 5, 6 тоот	2029.10.18
7.	Өлзий-Амгалан ХХК РД: 2340046	Эм, эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн хэрэглэгдэхүүн) импортлох-ханган нийлүүлэх	Дархан-Уул аймаг, Дархан сум, 10-р баг 380 Лха телевизийн байр	2029.12.31
8.	Монос Дархан ХХК РД: 4281357	Эм, эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн хэрэглэгдэхүүн) импортлох-ханган нийлүүлэх	Дархан-Уул аймаг, Дархан сум, 5-р баг, 20-3А байр	2029.12.31
9.	Энто ХХК РД: 5020166	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох-ханган нийлүүлэх	ЧД, 3-р хороо, Худалдааны гудамж 44 тоот	2029.12.10
Хоёр. Тусгай зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт бүртгэх байгууллагууд				

10.	Ивээлтгүн ХХК РД: 6131174	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох- ханган нийлүүлэх	ЧД, 4-р хороо, Дипломатын 95, 122-р байр, 1 давхар 1 тоот	2028.08.17
10.	Медиконт ХХК РД: 5417627	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох- ханган нийлүүлэх	БГД, 3-р хороо, 2-р хороолол, сүүлийн гудамж, 51/1 дугаартай барилын 3-4 давхар	2027.02.28
11.	Бөд тогтох ХХК РД: 8380279	Эм, эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн хэрэглэгдэхүүн) импортлох-ханган нийлүүлэх	ХУД, 7-р хороо жаргалант 21-р гудамж 519 тоот	2027.05.01
Гурав. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгаж, хаягийн өөрчлөлт бүртгэх байгууллага				
13.	Гүн тэнгэрийн нар ХХК РД: 5554241	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн хэрэглэгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох- ханган нийлүүлэх	СБД, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө- 15А/5, Амбассадор оффис 103 тоот	2029.11.06


Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2024
оны 12 дугаар сарын 09 -ны
өдрийн А/250 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛИЙН ЭРХ СЭРГЭЭЖ, ХАЯГИЙН
ӨӨРЧЛӨЛТ БҮРТГЭХ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хаяг байршил	Хугацаа
1.	Интернэйшнл медикал сентер ХХК РД: 5387051	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох-ханган нийлүүлэх	ХУД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 39/1 байр	2029.10.10
2.	Кореа фарм ХХК РД: 5836999	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох-ханган нийлүүлэх	СБД, Олимпын гудамж-210646 New Horiozns 102 тоот	2029.05.18


Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2024
оны 12 дугаар сарын 09 -ны
өдрийн 4 дугаар тушаалын дөрөвдүгээр
хавсралт 270



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЧИГЛЭЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ
БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл	Хүчингүй болгох чиглэл
1.	Бурят-Омбол ХХК РД: 5661277	Эм, эмнэлгийн хэрэгсэл (Лабораторийн оношилгооны хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэглэгдэхүүн) импортлох-ханган нийлүүлэх	Эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох- ханган нийлүүлэх

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2024
оны 12 дугаар сарын 09 -ны
өдрийн А/ дугаар тушаалын тавдугаар
хавсралт 266



ТӨСӨЛ ДЭМЖИГДЭЭГҮЙ БАЙГУУЛЛАГА

№	Байгууллагын нэр /РД/	Үйл ажиллагааны чиглэл
1.	Чамбай зам ХХК РД: 5808367	Эмнэлгийн хэрэгсэл (эмнэлгийн тоног төхөөрөмж) импортлох-ханган нийлүүлэх